

## АГУУЛГА

Нэг. Ерөнхий тойм

Хоёр. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа

- 2.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хийсэн ажил
- 2.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн
- 2.3 Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд санал өгөх талаар
- 2.4 Удирдлага, зохион байгуулалтын хийж хүрээнд хийсэн ажил
- 2.5 Бусад байгууллагатай хамтран ажиллах хүрээнд
- 2.6 Хүний нөөцийн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.7 Сургалтын ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.8 Санхүү төлөвлөлт, аж ахуйн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.9 Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.10 Мэдээллийн технологийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.11 Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Гурав. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа

- 3.1 Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.2 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.3 Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.4 Бичиг баримтжуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.5 Улсын бүртгэлийн архивын ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Дөрөв. Нөхөн сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Тав. Үндэсний энгийн цахим гадаад паспорт олголтын талаар

Зургаа. Стратеги команд штабын сургууль зохион байгуулах чиглэлээр

Долоо. Улсын бүртгэлийн нэг цэг байгуулах ажлын хүрээнд

Найм. “Цэвэрлэгээний өдөр” арга хэмжээг зохион байгуулсан тухай

Ес Бусад ажлын чиглэлээр

Арав. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

## **НИЙСЛЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

### **НЭГ. ЕРӨНХИЙ ТОЙМ**

Нийслэлийн улсын бүртгэлийн газар нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрөөс явуулж буй бүртгэлийн талаарх бодлого чиглэл, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хуульд заасан улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх гэсэн 2 үндсэн чиг үүргийн хүрээнд Газрын дарга, Захиргаа удирдлагын хэлтэс /11/, Харилцагчийн үйлчилгээний хэлтэс /4/, Архивын хэлтэс /9/, Дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс /395/ гэсэн нэгжүүдтэйгээр нийт 420 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус газар нь өөрийн харьяа 29 нэгжээс (нийслэл, 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн 6 төв, 13 Улсын бүртгэлийн цэг) Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.

## **ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **2.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:**

Тус газар нь “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Алсын хараа-2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.2.2 хэсгийн хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна.

Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар эцэслэн баталж, 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт “Иргэний үнэмлэхийг тоон гарын үсгийн хэрэгслээр ашиглаж болох бөгөөд энэ хуулийн 8.3-т заасан мэдээллийг түүний санах ойд байршуулна” гэж заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн тоон гарын үсэг олгох ажлыг нийслэлийн хэмжээнд дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтэс, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр олгож байна.

Тоон гарын үсэг олгох үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд хууль сахиулах байгууллагын албан хаагчид, төрийн байгууллагын албан хаагчид болон дүүргүүдийн нутаг дэвсгэрт байрлах аж ахуй нэгж байгууллагууд, мөн ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн 16-аас дээш насны иргэдэд тоон гарын үсэг олгох хуваарь баталж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд нийт 89182 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

### **2.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн:**

Тайлангийн хугацаанд Засгийн газрын 1 тогтоолын 1 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 1 заалт, нийт 2 шийдвэрийн 2 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газраас: Хүний нөөцтэй холбоотой 300 тушаал, чиглэл 7, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас: Нийслэлийн Засаг даргын захирамж-1, чиглэл 18, зөвлөмж 2, хуралдааны тэмдэглэл 1, Нийслэлийн онцгой комиссоос: захирамж 3, тушаал 1 тус тус ирснийг хяналтанд авч, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

### **2.3 Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд санал өгөх талаар:**

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн бусад байгууллагаас санал авахаар ирүүлсэн 22 хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төслийг албан хаагчдад танилцуулж, саналыг холбогдох газруудад хүргүүлсэн байна.

### **2.4 Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралд 6 удаа, удирдлагын шуурхай хуралдаанд 23 удаа, Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаанд 26 удаа тухай бүр оролцож өгөгдсөн үүрэг даалгаварын хүрээнд Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын удирдах албан хаагчдын шуурхай

хуралдааныг 12 удаа зохион байгуулж үүрэг даалгаваруудыг холбогдох хэлтсүүдэд хүргүүлэн биелэлтийг ханган ажилласан.

Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын даргын 71 тушаал боловсруулж, батлав.

Тус газрын Захиргаа удирдлагын хэлтсээс 3, Харилцагчийн үйлчилгээний хэлтсээс 5, Архивын хэлтсээс 3 чиглэл нийт 11 удаагийн чиглэл боловсруулан хүргүүлсэн.

Тус газар нь тайлангийн хугацаанд нийт 98 төрлийн тайлан, мэдээ, судалгааг давхардсан тоогоор 300 гаруй удаа холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна.

## **2.5 Бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр:**

Тус газар өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн халамжийн газар, Нийгмийн даатгалын газар, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Гэр бүл хүүхэд залуучуудын газар”, “Хотын засаглалыг сайжруулах” төсөл, Нийслэлийн эрүүл мэндийн төв, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв, Гэмтэл согог үндэсний төв, Түлэнхийн төв, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа баривчлах байр, Эмэгтэйчүүдийн хорих анги, Соёл урлагийн их сургууль, Хаан банк, бүх шатны ерөнхий боловсролын сургуулиуд, хууль хяналтын болон холбогдох төрийн бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Гэрэгэ системс” ХХК, “Улаанбаатар Буян” ХХК, “Монгол Шуудан” ХХК, “Дэлхийн Зөн” олон улсын байгууллага, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, “Голомт банк”, “Төрийн банк”, “Богд банк”, “Хаан банк” зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан.

### **Нийслэлийн улсын бүртгэлийн газар:**

- Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, цахим сүлжээний хэвийн ажиллагааг хангах, мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан төрийн үйлчилгээ, лавлагааг орон зай, цаг хугацаанаас үл хамааран иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, төрийн ой санамжийг бий болгох, түүнд суурилсан бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн цахим машин 17, төлбөр тооцооны пос машин 14, Гэрэгэ киоск 8, нийт 39 киоск, пос машин шинээр үйлчилгээнд оруулж, төлбөр тооцоог хүлээн авсан байна.



➤ Улсын бүртгэлийн үйлчилгээний бүрдүүлэх материалын жагсаалтыг QR код уншуулан харах боломжийг бүрдүүлсэн. Иргэний, эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний бүрдүүлэх материалын жагсаалт тус бүрд QR код үүсгэн үйлчилгээний цонхнуудад байршуулав.



➤ Харилцагчдад зориулсан үйлчилгээ авах алхам алхмаар үйл явцыг тодорхойлсон заавар, иргэний болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний бүрдүүлэх материалын 30 постер боловсруулан байгууллагын цахим хуудас, нүүр номоор сурталчлан ажиллаж байна. Тухайн харилцагч үйлчилгээ авах алхамд байршуулсан бүрдүүлэх материалын болон үйлчилгээний нэгжүүдийн байршлыг харуулсан QR кодыг уншуулан бүх мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлэв.



➤ Нийслэлийн хэмжээнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй төв, цэгүүдийн байршлуудад QR код үүсгэв. Тухайн QR кодыг гар утсандаа уншуулснаар google.maps дээр харах боломжийг бүрдүүлж өгсөн.



### **Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар тус газрын албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон. Энэ тогтоолоор өмнө нь ТЗ-6-1 ээс ТЗ-6-5 шатлалаар цалинжиж байсан 301 албан хаагчийн үндсэн цалин 924456 болж өөрчлөгдсөн.


Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 98, 99, 100, 101 дүгээр тушаалаар албан хаагчид олгох нэг өдрийн хоол, унааны нөхөх төлбөрийг төрийн захиргааны албан хаагч 7500 төгрөг, хяналтын улсын байцаагч 15000 төгрөг, төрийн үйлчилгээний албан хаагч 10000 төгрөг авахаар шинэчлэн тогтоож олгосон.

Төрийн үйлчилгээний 3 албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэл ТҮ-4-өөс ТҮ-7 болж ахисан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар зүйлийн 8.15.4 дэх заалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд нэг удаагийн буцалтгүй тусламжийг 4 албан хаагчид 2,200.0 мянган төгрөг олгосон.

Засгийн газрын 2023 оны 301 дугаар тогтоолын дагуу байгууллагын албан хаагчдад 2 удаа хагас, бүтэн жилийн үр дүнгийн урамшууллыг давхардсан тоогоор 520 хүнд 202,721.9 мянган төгрөгийг олгосон.

Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус газрын албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, спорт аяллын төрлөөр хичээллэх, явган аяллын шилдэг баг тамирчдыг шалгаруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Хөдөлгөөн эрүүл мэнд” явган аялал зохион байгуулсан.



Удирдлага, ажилтнуудын санал бодол, хандлагын судалгааг 2023 оны 5 дугаар сард авч нэгтгэн үр дүнг удирдлагад танилцуулсан. 7 үндсэн хэсгээс бүрдсэн уг судалгаанд нийт 332 албан хаагч буюу 83 хувь нь оролцсон байна. 2023 оны 11 дүгээр сарын 3-10-ны өдрүүдэд албан хаагчдын санал бодол, хандлагын судалгааг дахин авсан. Нийт 294 албан хаагч хамрагдсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй албан хаагчдын судалгаа гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн. Тус газрын хэмжээнд 7 хүүхэд байна. 1 албан хаагчид нэг цагийн завсарлага нэмж олгосон.

Тус газар Сөүл эмнэлэгтэй хамтран 40 албан хаагчийг эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. /Захиргаа удирдлага, Архив, Харилцагчийн үйлчилгээ, Багануур, Багахангай, Баянгол, Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид хамрагдаад байна/ Багахангай 4, Чингэлтэй 7 албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулсан. Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс 5, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс 5 албан хаагчийг өдрийн эмчилгээнд хамруулж байна.

Баянзүрх дүүргийн улсын бүртгэлийн хэлтсээс санаачлан 32 албан хаагчийг аяллын арга хэмжээнд 2023 оны 5 дугаар сард хамруулсан.

2023 оны 10 дугаар сард зохион байгуулсан “Хөдөлгөөн эрүүл мэнд, Эрүүл агаар-эм” явган аялалд тус газрын 246 албан хаагч хамрагдсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачлагаар "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяны хүрээнд хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж, дадал болгох зорилгоор тус аянд газар, хэлтсийн албан хаагчид идэвхтэй хамрагдсан.

Захиргаа удирдлагын хэлтсээс албан хаагчдад газар эзэмшүүлэхээр Багахангай, Баянзүрх, Налайх дүүргийн газрын албанд хамтран ажиллах санал тавьсан.

Харилцагчийн үйлчилгээний хэлтэс Иргэдийн хэрэглээний боловсролын төв ТББ-тай хамтран зохион байгуулсан “Эрүүл амьдралын зөв дадал зуршил, Дархлаа” сэдэвт сургалтад 20 албан хаагч, “Амьдрах урлаг ба йога бясалгал” сэдэвт сургалтад 8 албан хаагч хамрагдсан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аяны хүрээнд Багануур дүүргийн 11 албан хаагч сургалтад хамрагдсан.

Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтсээс Уламжлалт анагаах ухааны судалгааны хүрээлэн /Хуучнаар Улаанбаатар сувилал/-ийн 4 мэргэжлийн эмчийг урьж 10 дугаар сард албан хаагчдыг эмчийн үзлэгт оруулан, эмчилгээ шаардлагатай гэсэн 8 албан хаагчийг сувилгаа эмчилгээнд хамруулж байна.

Тус газраас “Стрессгүй ажлын байр буюу ажлын байрны стрессийг даван туулах” сэдэвт сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулж нийт 290 албан хаагч хамрагдсан байна.

## **2.7 Сургалтын ажлын хүрээнд:**

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан “Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын сургалтын төлөвлөгөө”-г баталж, 208 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 3615 ажилтан, албан хаагч хамруулсан.

Үүнд:

- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газраас 40 удаагийн сургалтаар-967
- ❖ Нийслэлийн улсын бүртгэлийн газраас 25 удаагийн сургалтаар-752
- ❖ Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүд 52 удаагийн сургалтаар-651
- ❖ Бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан 91

удаагийн сургалтанд 1245 ажилтан, албан хаагчдыг хамруулсан байна.

Харилцагчдад зориулсан 29 удаагийн сургалт зохион байгуулж, 3799 харилцагч хамрагдсан байна.



## **2.8 Санхүү, аж ахуйн чиглэлээр:**

Газрын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Олон улсын стандартад нийцүүлэн батлагдсан маягт зааврын дагуу хөтлөх, газрын болон дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

2023 оны 3 дугаар сард Санхүүгийн нэгдсэн системд шилжиж байгаатай холбогдуулан Сангийн яам, Нийслэлийн төрийн сангаас зохион байгуулсан сургалтад нягтлан бодогч нар хамрагдаж санхүүгийн гүйлгээ цахимаар хийгдэж байна.

Хууль зүй дотоод хэргийн яам Санхүүгийн нэгдсэн e-accounting программ нэвтрүүлж эхэлж буйтай холбогдуулан нягтлан бодогчид, нийслэл болон дүүргүүдийн нярав нар 3 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд сургалтад хамрагдаж 2023 оны Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл, гүйлгээ, үндсэн хөрөнгө болон бараа материалыг нэр төрөл, эд хариуцагч нараар тус тус хөрвүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

## **НИЙСЛЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР**